

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 12 сар | Дугаар 25

ГАРЧИГ

- 2-3 Бодлогын нийтлэл
- 4 Зохицуулалтын мэдээ
- 5-6 Цар тахалтай холбоотой даатгалын шинэ бүтээгдэхүүн гараад хэрэгжиж байна
- 6-7 Тайлбар ба зөвлөмж
- 8 Финтек ба КОВИД-19
- 9-10 Монголын бизнесийн орчин 2020
- 11 Олон улсын санхүүгийн корпорацийн
- 12 Мөнгө угаах гэж юу вэ?
- 13 Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах
- 14 Байгууллагын соёл
- 15-16 Албани улсын КОВИД-19-ийн нөлөөллийн эсрэг эдийн засгаа сэргээхэд хэрэгжүүлж буй бодлого
- 17-19 Санхүүгийн зах зээлийн сарын тойм
- 20 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976-51-264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар



Мөнгөжилгээ

Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, үе үеийн ажилтан, албан хаагчид, салбарын холбоод, харилцагчид, иргэд Та бүхэндээ айлчлан ирж буй 2021 ондоо амжилт бүтээлээр дүүрэн байхын ерөөлийг дэвшүүлэн шинэ жилийн мэндийг хүргэе!

Монгол улс Олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-ын "Саарал жагсаал"-аас гарч улиран одож буй энэ онд тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлсэн нь төрийн байгууллагууд болон санхүүгийн зах зээлд оролцогч Та бүхний идэвх, санаачлагатай хамтын ажиллагааны үр дүн гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

2020 он маань хэдийгээр дэлхий нийтэд тархаад буй корона вируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын давагдашгүй хүчин зүйлийн улмаас нийгэм, эдийн засаг, санхүүгийн салбарын бүхий л түвшинд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн хэдий ч улс орон бүр хамтын хүчээр бүхий л боломж, бололцоогоо дайчлан даван туулсан он жил байлаа. Санхүүгийн зохицуулах хороо болон зохицуулалтын байгууллагууд ч цар тахлын үед үйл ажиллагаагаа бүрэн цахим горимд шилжүүлэн тасралтгүй ажиллаж ирлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зүгээс энэ онд хийгдсэн онцлох ажлуудаас дурдвал, Хөрөнгийн зах зээлд төлбөр тооцооны T+2 системийг нэвтрүүлж, биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгож, биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох таатай нөхцөл бүрдүүлж, үнэт цаасны давхар бүртгэлийн системийг нэвтрүүлэн хоёр биржийн хооронд үнэт цаасыг чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах орчинг бүрдүүлж, "НОСК" ХХК-аар дамжуулан хэрэгжүүлж буй түрээслээд өмчлөх хөтөлбөрийн хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэн санхүүгийн хэрэгсэл болгоод байна.

Даатгалын зах зээл дээр коронавирустэй холбоотой даатгалын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн. Тухайлбал, "Нэйшнл лайф даатгал" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд халдварын өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах "Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал", "Мандал даатгал" ХК нь "Ковид даатгал" бүтээгдэхүүн нь Ковид-19 өвчин тусч, тусгаарлагдсаны улмаас алдах орлогыг үнэлгээний хязгаарын хүрээнд багтаан нөхөн төлбөр хэлбэрээр авах боломжтой бүтээгдэхүүн гаргасан.

УИХ, ЗГ-аас гаргаж буй шийдвэрүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, банк бус санхүүгийн байгууллагууд болон хадгаламж, зээлийн хоршоодын зээлдэгчдийн хүсэлтийн дагуу зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, зээлийн хугацааг сунгах талаар зохицуулалтын байгууллагад үүрэг даалгавар, мэдэгдэл хүргүүлэн харилцагчдаа зээлийн зөөлөн бодлогоор дэмжин ажиллаа. Мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгосноор батлан даалтын хэмжээ нэмэгдэж байна.

Санхүүгийн зохицуулах хороо мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын салбарыг бүртгэл зөвшөөрөлтэй болгох, хяналтад оруулах ажлыг энэ онд эхлүүлж нийт 167 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, 429 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тусгай зөвшөөрлийг олгож, зохицуулалтад оруулаад байна.

Ирэх онд Санхүүгийн зохицуулах хороо салбарын оролцогчдыг улам бүр чадавхжуулах, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд хямд үнэтэй, өргөн сонголт бүхий санхүүжилтийн арга хэрэгслийг санал болгох зэрэг зорилтуудыг дэвшүүлээд байна.

Санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө сэтгэл, итгэл, оюунаа зориулан ажилладаг нийт албан хаагчид, бидэнд итгэл хүлээлгэн хамтран ажилладаг мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагууддаа, мөн иргэд, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагч та бүхэндээ талархал илэрхийлье.

2021 он Санхүүгийн зохицуулах хорооны хувьд эрхэм зорилго, алсын хараа, зорилго, зорилтдоо тууштай байж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг өндөр түвшинд хамгаалж, зах зээлд гарч буй өсөлт, хөгжлийг тогтвортой үргэлжлүүлж, амжилтаа ахиулсан жил болно гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛСНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын ахлах зөвлөх Д.Соёлмаатай зээлийн мэдээллийн сангийн талаар ярилцлаа.

Зээлийн мэдээлэл, зээлийн мэдээллийн сан гэж юу вэ гэдэг асуултаар яриагаа эхлүүлье.

Зээлийн мэдээлэл гэдэг нь зээлдэгчийн зээлдүүлэгчийн өмнө хууль, гэрээгээр хүлээсэн зээл, төлбөрийн талаарх мэдээлэл юм. Харин зээлийн мэдээллийн сан гэдэг нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу нийлүүлсэн зээлдэгчийн зээлийн мэдээлэл болон бусад төлбөрийн мэдээллийг агуулж буй Монголбанкны зээлийн мэдээллийн нэгдсэн сан гэж ойлгож болно.

Зээлийн мэдээлэл, зээлийн мэдээллийн сантай холбогдох харилцааны эрх зүйн зохицуулалтын талаар хэлж өгнө үү. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэж хэн бэ, ямар байгууллагууд мэдээлэл нийлүүлэх үүрэгтэй вэ?

Санхүүгийн зах зээлд томоохон хэмжээний өөрчлөлт орж шинэчлэгдэх, хөгжих хэрээр зах зээлд оролцогч иргэд, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа өөр хоорондоо хамааралтай болж санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлага үүсдэг. Үүнтэй зэрэгцээд цаг үеэ олсон сайн туршлага нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүсдэг. 2011 онд Улсын Их Хурлаас Зээлийн мэдээллийн тухай хуулийг баталснаар эрх зүйн зохицуулалт бий болсон. Энэ хуульд нийцүүлэн эрх бүхий этгээдээс баталсан журмууд ч байгаа.

Хуулиар банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, санхүүгийн түрээсийн компани, төрийн байгууллагууд, үүрэн холбооны операторууд, Монголбанктэй зээлийн мэдээллийн сан ашиглах гэрээ байгуулсан хуулийн этгээдүүд хамаарч байна.

ХЗХ-дын тоо, зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулсан хоршоодын талаарх мэдээллийг өгнө үү?

Өнөөдрийн байдлаар Хорооноос олгосон

тусгай зөвшөөрөлтэй 247 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 148 ХЗХ Улаанбаатар хотод, 99 ХЗХ орон нутагт байна. Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас ирүүлсэн судалгаанаас үзэхэд нийт ХЗХ-дын 42.1 хувь буюу 104 ХЗХ хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан байна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа ХЗХ-дын 58 хувь буюу 143 ХЗХ зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулаагүй. Судалгаанаас үзэхэд хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хуулийн хэрэгжилт хангахгүй байгаа шалтгааны талаар тодруулбал?

Зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулаагүй ХЗХ-дыг аваад үзэхэд 48 хувь буюу 69 ХЗХ нь Улаанбаатар хотод, 52 хувь буюу 74 ХЗХ орон нутагт байна. ХЗХ-д манай орны нийт нутгаар тархсан байдаг. Орон нутагт, тэр дундаа алслагдсан аймаг, сумдад үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-дын хувьд зээлийн мэдээлэл солилцоход шаардлагатай хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, програм хангамж, суурин интернет, шилэн кабели байхгүй зэрэг хүндрэл байдаг.

Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, мөн Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүү бууруулах стратеги”-д зээлийн мэдээллийн санд санхүүгийн байгууллагууд, ХЗХ-дыг хамруулах, олон улсын жишигт нийцсэн програм хангамжийг ашиглах зэрэг зээлдэгчийн эрсдэлийг бодитоор үнэлэх, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ажлууд тусгагдсан. Энэхүү ажлыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд хариуцуулсан тул хууль тогтоолын хэрэгжилтийг хангуулахад 2 байгууллага хамтран ажиллаж байна. Эхний ээлжинд хотын ХЗХ-дыг бүрэн хамруулж, дараагаар

нь орон нутгийн ХЗХ–дыг гэх зэргээр үе шаттай арга хэмжээ авахаар зорьж байна.

ХЗХ гишүүдэд олгосон зээлээ хэрхэн ангилдаг вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–д үндэслэн ангилдаг. Энэ жилийн хувьд дэлхий нийтэд гарсан цар тахалтай холбоотойгоор МУ–ын Засгийн газраас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоож, хорио цээрийн дэглэмтэй байснаас эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн ажиллагаа саатах, улмаар орлого тасалдах, санхүү төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн. Энэхүү нөхцөлд санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2020 онд дээрх журамд 2 удаа өөрчлөлт оруулж, 2020 оны эцэс хүртэл хугацаанд зээлийн ангиллын хугацааг өөрчлөн мөрдүүлж байна. 2020 оны 11 дүгээр сарын байдлаар авсан мэдээгээр ХЗХ–д 3,340 зээлдэгчийн 10.6 тэрбум төгрөгийн зээлийг хойшлуулах шийдвэр гаргасан байна. Энэ нь 2020 оны 10 дугаар сарын 30–ны өдрөөс 3.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Журамд өөрчлөлт оруулах бодлогын шийдвэр гаргасны үр дүнд 4,040 зээлдэгчийн 19.6 тэрбум төгрөгийн зээлийг ангилал буурахаас хамгаалсан байна. Дотоодын нөхцөл байдалд тохируулан энэ шийдвэрийг 2021 оны 7 сар хүртэл сунгахаар холбогдох судалгааг хийж байна.

ХЗХ нь зээлийн мэдээллийг санд мэдээлэл нийлүүлснээр гарах үр дүн, ач холбогдлын талаар хэлж өгнө үү?

ХЗХ нь Монголбанкны зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулж хамтран ажилласнаар гишүүдэд зээл олгох шийдвэр гаргахдаа

сангаас мэдээлэл авч, авсан мэдээлэлд үндэслэн зээлдэгчийн зээлийн ангилал нь хэр сайн бэ, тухайн этгээдийн санхүүгийн хариуцлага хэр вэ, аливаа төлбөр, тооцоотой юу гэдгийг тодорхойлох, түүнчлэн зээл эргэн төлөх чадварыг үнэлэх зэргээр зээлийн шийдвэрийг хялбар гаргах боломжийг олгодог. Мөн чанаргүй зээлийн эрсдэл үүсэх, хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Зээлийн түүхэн дээр суурилан төрөл бүрийн статистик, нэгдсэн тайлан мэдээ, зээлжих чанарын оноо тооцох, зээлийн эрсдэлийг тооцох, гишүүдийн зээлийн мэдээллийг хурдан шуурхай авах, эдгээр мэдээллийг нэгтгэн төвлөрүүлж, боловсруулалт хийх зэрэгт ашиглаж болно. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлснээр зээлдэгчийн эрсдэлийг бодитоор үнэлэх боломжтой болно, ингэснээр тухайн зээлдэгчийг ч, зээлдүүлэгчээ ч, санхүүгийн салбараа ч давхар хамгаална.

Иргэндээ, ХЗХ–ны гишүүний хувьд үүсэх давуу талын талаар хэлэлгүй орхиж болохгүй байх?

Зээлийн мэдээллийн сангийн зорилго бол сайн зээлдэгчийг дэмжих юм шүү дээ. Өөрөөр хэлбэл зээлдэгч зээлээ цаг хугацаанд нь төлж чадаж байвал зээлийн мэдээллийн санд хэвийн ангилалд ангилагдаж сайн түүхтэй болж хадгалагдана. Сайн түүх бүрдүүлэх нь ХЗХ–дын гишүүдийн хувьд, иргэний хувьд дараа дараагийн санхүүгийн харилцаанд ороход маш чухал юм. Хүү багатай, урт хугацаатай зээл авахад сайн түүхтэй байх нь дэмжлэг болно.

Зээлээ хугацаа хэтрүүлж төлсөн, зээлийн муу түүхтэй гишүүдэд зээл олгож болохгүй гэж ойлгож болох уу?

Тухайн хүний санхүүгийн сахилга бат хэр байна гэдэг нь зээлийн түүхээс харагддаг. Муу түүхтэй гишүүдэд зээл олгож болохгүй

гэсэн эрх зүйн зохицуулалт байхгүй хэдий ч зээлийн мэдээллийн санд үүссэн мэдээлэлд үндэслэн ХЗХ нь зээл авсан гишүүдийн өмнөх болон одоогийн санхүүгийн чадамж, сахилга бат, эрсдэлийг тооцон урьдчилан сэргийлэх зорилгоор зээл олгохгүй байх тохиолдол түгээмэл гардаг.

Зээлдэгч зээлээ хугацаанд нь төлөхгүй бол ямар хариуцлага хүлээх вэ гэдгээ судлаагүйгээс, гарах эрсдэлийн талаар ойлголт байхгүйгээс, зээлийн гэрээтэй сайн танилцалгүйгээр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах, өөрийн болон өрхийн орлого, зардлын харьцааг тооцохгүйгээр байгаа боломжоосоо өндөр хэмжээний зээл авснаас зээлийн эргэн төлөлтийг хийж чадахгүй байх хүндрэл гарч байгаа нь санхүүгийн харилцаанд орох мэдлэг, мэдээлэл дутмагтай шууд хамааралтай гэж ойлгодог.

Эцэст нь, ХЗХ нь зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ шинэчлэн байгуулаагүй бол юуг анхаарах, ямар бичиг баримтыг бүрдүүлж өгөх вэ?

Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны А–57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”–ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж байна. Хорооноос нийт ХЗХ–дод хандаж цахим шуудангаар болон албан бичгээр холбогдох мэдээлэл, мэдэгдлийг удаа дараа хүргүүлсэн. ХЗХ–дод тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгодог, хугацааг сунгахад харгалзан үзэх нэг нөхцөл нь зээлийн мэдээллийн санд холбогдсон эсэх, холбогдсон бол мэдээллийг үнэн зөв нийлүүлж байгаа эсэхэд Хороо хяналт тавьж байна.

Ярилцсанд баярлалаа.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

“ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”-ЫН ТӨСӨЛД САНАЛ АВЧ ЭХЭЛЛЭЭ

Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу олон нийтээс санал авахаар “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын төслийг Хорооны цахим хуудсанд байршуулаад байна.

Журмаар анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компани хариуцан зохион байгуулж, санал болгох үнийг тогтоох, үнэт цаас бүртгэх ажиллагааг түргэн шуурхай, чирэгдэлгүй гүйцэтгэх, арилжаа эрхлэх болон төрийн зохицуулагч байгууллагын бүртгэл хоорондын зааг, ялгааг тодорхойлж, аж ахуйн нэгжүүд үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа санал болгож санхүүжилт татах сонирхлыг нэмэгдүүлэх боломж бий болно. Цаашилбал, үнэт цаас гаргагчийн мэдээлэл, тайлагналын тогтолцоог сайжруулж, мэдээллийн төрлийг нарийвчлан тогтоож маягтжуулах, мэдээлэх үүрэгтэй этгээдийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч аудит, хууль, үнэлгээний компаниудын хараат бус байдал, гаргаж буй дүгнэлтийг олон улсын стандартад нийцүүлж чанарыг сайжруулахтай холбоотой зохицуулалтыг бий болгох ач холбогдолтой.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР БОЛОН УТСААР ХҮЛЭЭН АВЧ БАЙНА

Засгийн газраас баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 183 дугаар тогтоолын 8 дахь заалтад “Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчид ямар нэгэн дарамт үүсгэхгүй байхаар төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээнд өөрчлөлт оруулах зохицуулалтын арга хэмжээг 2021 оны долдугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд авч хэрэгжүүлэх шийдвэр гарсан.

Энэ шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо


11 дүгээр сарын 23-наас 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд цахим хуудас /<http://www.frc.mn/i/Feedback/> болон 51-262608 утсаар иргэдээс ирсэн нийт 691 өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгч, тухай бүрт нь хариу хүргүүлж ажиллалаа.

Нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн 75.0 хувь буюу 518 нь утсаар хүлээн авсан дуудлага бол 25.0 хувь буюу 173 нь цахимаар ирүүлсэн өргөдөл, хүсэлт эзэлж байна. Иргэдээс ирсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 56.6 хувийг ББСБ-уудаас олгосон зээлийн гэрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой эзэлж байна. Харин 42.3 хувийг барьцаалан зээлдүүлэх газар зэрэг Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад хамаардаггүй хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол байлаа.

Цаашид иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын зээлийн эргэн төлөлт, зээлийн гэрээний хугацаа сунгах, нөхцөлд өөрчлөлт оруулах зохицуулалтын арга хэмжээг 2021 оны долдугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлээгүй ББСБ-уудын талаарх өргөдөл, гомдлыг Хорооны /<http://www.frc.mn/i/Feedback/> цахим хуудас болон 51-261275, 51-262608 утсаар хүлээн авч, шуурхай шийдвэрлэж ажиллах болно.

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН АЖИЛТНУУДЫН СУРГАЛТЫГ ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛЛАА

СЗХ-ны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам-ыг баталсан. Энэхүү журмын 2.1.6.-д “брокер, агент нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтанд хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын холбоодтай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 14-ний өдрийн хугацаанд цахимаар зохион байгууллаа.



БАЙР СУУРЬ

ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБООТОЙ ДААТГАЛЫН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ГАРААД ХЭРЭГЖИЖ БАЙНА



Ковид –19 цар тахалтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэгтэй ярилцлаа.

Ковид–19 вирусийн нөлөөгөөр эдийн засагт эрсдэлтэй нөхцөл байдал үүслээ. УИХ, Засгийн газраа гаргасан шийдвэрийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Санхүүгийн зохицуулах хороо нийт 5,600 гаруй санхүүгийн үйлчилгээ эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг бөгөөд 2020 оны 4 дүгээр сарын 06–ны өдрөөс эхлэн холбогдох өргөдөл, хүсэлтийг цахим <https://license.frc.mn/home/> онлайн/–аар хүлээн авч шийдвэрлэж байна. Хорооны үйл ажиллагаа бүхэлдээ цахим горимд горимоор хэвийн ажиллаж байна. Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор Хорооны зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт 495 ББСБ руу мэдэгдэл хүргүүлж, Хороо өөрийн цахим хуудсаар дамжуулан ББСБ–ын нийт зээлдэгчдэд хандан <http://www.frc.mn/a/3445/> мэдэгдэл гаргасан хүсэлт, гомдлыг Хорооны тусгай утас болон цахим хэлбэрээр авч ажиллаж байна. Тухайлбал,

2020 оны 11 дүгээр сарын 23–ны өдрөөс 12 дугаар сарын 22–ны өдрийг хүртэлх хугацаанд иргэдээс нийт 946 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авсны утсаар нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн 79.9 хувь буюу 756 иргэний дуудлага, цахимаар 20.1 хувь буюу 190 иргэний хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө, зааварчилгаа өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдтэй холбогдон иргэдээс хандсан өргөдөл, гомдол, хүсэлтийн талаар тухайн зээлдэгч байгууллагад мэдэгдэн, хүсэлтийг шийдвэрлүүлэх, энэ талаар иргэдэд тухай бүр хариу хүргүүлэн ажиллаж байна.

Салбар бүрээр хэрэгжүүлж буй ажлуудын талаар товч танилцуулья.

Монголын хөрөнгийн биржийн арилжаа цахим горимоор хэвийн явагдаж байна. Тухайлбал, Үнэт цаасны хадгаламжийн байгууллага, Клирингийн төв зэрэг дэд бүтцийн гол байгууллагууд үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, өмчлөх эрхийн бүртгэлийг бүхэлдээ онлайн горимоор

хэвийн үргэлжлүүлж байгаа бөгөөд хатуу хөл хорионы энэ үед хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээ багассан ч 2020 оны 11 дүгээр сарын 11–ний өдрөөс 12 дугаар сарын 21–ний өдрүүдэд дунджаар 290.8 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Хорооны хуралдаанаар биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмыг баталсан нь компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах эрх зүйн орчин бүрдэж, үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэх, жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох таатай нөхцөл бүрдсэн. “Үнэт цаасыг бүртгэх журам”–д хоёр биржийн хооронд иргэн, ААН өөрийн эзэмшлийн хувьцааг чөлөөтэй хөрвүүлэх эрх зүйн зохицуулалт хийсэнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 12 дугаар сарын 09–ний өдөр “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”–ийн Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй 263,885,433 ширхэг хувьцааг бүртгэж, тухайн компанийн хувьцааг эзэмшиж буй Канад болон Монгол Улсын иргэн, ААН өөрсдийн эзэмшлийн хувьцааг хоёр биржийн хооронд чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах нөхцөл бүрджээ. “Носк нэг ТЗК” ХХК нь 420 иргэнд олгосон түрээслээд өмчлөх орон сууцны зээлийг багцалсан 34.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэж, Хорооны 2020 оны 12 дугаар сарын 09–ний өдрийн 994 дүгээр тогтоолоор хоёрдугаар ээлжийн үнэт цаас гаргагч “Носк хоёр” ХХК–д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгосон байна.

Банк бус санхүүгийн байгууллагын тухайд, “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–д 2 удаа өөрчлөлт оруулж, зээлийн ангиллыг бүртгэх хугацааны үзүүлэлтүүдийг суллагч өгсөн нь 2020 оны 3 дугаар улирлын байдлаар зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй активын хэмжээ 13.2% байснаас 27.1% болж 187.2 тэрбум төгрөгийн зээлийн ангилал огцом буурахаар байсан тул салбарын эрсдэлийг бууруулах, зээлдэгчдийн зээлийн ангилал муудахаас сэргийлсэн чухал бодлогын шийдвэр болсон. Мөн Хорооны 2020 оны 12

дугаар сарын 998 дугаар тогтоолоор энэхүү журмыг шинэчлэн баталж, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалж, активыг чанаргүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, хугацаа хэтрэх ангиллыг бууруулсан. 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 189.9 мянган зээлдэгч 248.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд 262 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 185.8 мянган зээлдэгчийн 216.0 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгасан байна.

Мөн УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 352 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, журам”-д зохицуулалтын өөрчлөлтүүдийг оруулж 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөж ажиллаж байна. Энэ хугацаанд нийт 39 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 6.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаснаар 13.4 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна.

Даатгалын компаниуд COVID19-ийн үед цахим горимоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, даатгалын бүх компани утсаар болон фейсбүүк мессенжер буюу чатбот ашиглан, 5 даатгалын компани дээрх төрлөөс гадна цахим болон гар утасны аппликейшн ашиглан зөвлөгөө өгөх, даатгалын тохиолдлын талаар мэдээлэл болон нөхөн төлбөрийн баримт материалыг хүлээн авах зэргээр даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд даатгалын компанийн хувьд нийтдээ 4462 даатгалын тохиолдол бүртгэж, 2054 тохиолдлын 1128.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бол одоогоор 2254 даатгалын тохиолдлыг шийдвэрлэгдээгүй байна.

Даатгалын зах зээл дээр коронавирустэй холбоотой даатгалын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн. Тухайлбал, “Нэйшнл лайф даатгал” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд халдварын өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах “Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ыг гаргасан (1800 орчим төрийн албан хаагч даатгалд хамрагдсан ба нас барсан тохиолдолд-12

сая төгрөг олгоно.) бол “Мандал даатгал” ХК-ийн “Ковид даатгал” нь Ковид-19 өвчин тусч, тусгаарлагдсаны улмаас алдах орлогыг үнэлгээний хязгаарын хүрээнд багтаан нөхөн төлбөр хэлбэрээр авах боломжтой бүтээгдэхүүн /Тус компани өөрийн харилцагч 75.000 даатгуулагчийг уг эрсдэлээс үнэгүй даатгасан, харилцагч биш 400 орчим даатгуулагч хамрагдсан, тохиолдол үүсвэл 1 сая, гэр бүлээрээ даатгасан бол 3 сая төгрөг олгохоор/ байхаар гаргасан.

“Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2 удаа өөрчлөлт оруулсны үр дүнд 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 117 ХЗХ-ны 6,253 зээлдэгчийн 22.3 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирүүлснээс 4,950 зээлдэгчийн 14.1 тэрбум төгрөгийн зээлийг хойшлуулах шийдвэр гаргасан байна. ХЗХ-нь гишүүддээ өрийн дарамтад оруулахгүй, төлбөрийн чадварт нь нийцүүлэн зээлийн нөхцөлийг өөрчлөн хугацааг сунгах, нэмэгдүүлсэн хүү, алданги, торгууль ногдуулахгүй, хүүг нэгтгэн тооцож дарамт үүсгэхгүй, үйлчилгээний шимтгэл, хураамж авахгүйгээр зээлдэгчдийг дэмжиж ажиллах анхааруулгыг нийт хадгаламж, зээлийн хоршоодод хүргүүлсэн.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЁС ЗҮЙН ЖУРАМ

Журам дүрмийн тайлбар ба зөвлөмж

Даатгалын салбарын комплаенсийн зөвлөмж /мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх урьдчилан сэргийлэх зөвлөмж/ Олон Улсын Даатгалын Зохицуулагчдын Холбоо-с /IAIS/ даатгалын секторт зориулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тэмцэх /МУТСТ/ зорилгоор 2004 онд гарын авлагыг гаргасан. Уг гарын авлага нь хар жагсаалтнаас гараад удаагүй байгаа Монгол улсын хувьд нэн чухал ач холбогдолтой баримт материал юм. Энэхүү гарын авлагыг ашиглан дараах зөвлөмжүүдийг хүргэсэн болно.

Даатгалын салбарын МУ болон ТС эмзэг байдал


Даатгалын салбарын хувьд мөнгө угаах /МУ/ болон терроризмыг санхүүжүүлэх /ТС/ эрсдэл багатайд тооцогддог ч гэмт хэрэгтнүүд зохицуулагч байгууллага хараа хяналт багатай салбар луу илүү анхаарлаа хандуулан гэмт хэргийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж болох өндөр магадлалтай. Тиймээс эрсдэл багатай тооцогддог ч хяналт зохицуулалтаа бууруулалгүйгээр үргэлж сайжруулах шаардлагатай.

МУ эмзэг байдал нь дараах хүчин зүйлээс шалтгаална:


1) Даатгалын бүтээгдэхүүний эрсдэл



2) Даатгалын гэрээний төвөгтэй ойлгомжгүй байдал



3) Борлуулалтын суваг



4) Төлбөр гүйцэтгэх хэлбэр

5) Гэрээний хууль эрх зүйн орчин

Комплаенсийн ойлголт, ач холбогдол


Комплаенсын үйл ажиллагаа 2 түвшинд явагддаг:

1. Зохицуулагч байгууллагаас тавьсан, мөрдөх ёстой шаардлага хэм хэмжээг сахиулах /regulatory compliance/

IAIS нь тухайн улсын хяналт шалгалтын байгууллага даатгалын салбарт зориулсан МУТСТ гарын авлагатай байх нь нэн чухал гэж авч үздэг. Уг гарын авлага нь даатгалын салбарын онцлог ба шинж чанар,ФАТФ-аас мөрдүүлж буй зөвлөмжүүд ба тухайн улсын МУТСТ хуультай нийцүүлэн гаргасан байна гэж заасан байдаг.

2. Хууль эрх зүйн орчны хүрээнд тухайн байгууллагын дотооддоо баталсан дүрэм журмуудыг сахиулах /internal compliance/

МУТСТ зорилгоор тухайн даатгалын компани дараах хамгаалалтын бүтэцтэй байх нь өөрсдийгөө эрсдэлээс урьдчилан сэргийлж чадна.



Тухайн байгууллага нь өөрсдийн дотоод хяналтын хөтөлбөртэй байх нь ажилчиддаа болон дээд удирдлагуудад МУТСТ боловсролыг олгодог бөгөөд хариуцлага тооцох бодлогыг хэрэгжүүлэх үндэс болдог. Дотоод хяналтын хөтөлбөрт дараах агуулгатай байна:

Даатгуулагчийг таньж мэдэх үйл ажиллагаа	Сэжигтэй гүйлгээний тайлан	Бусад
<ul style="list-style-type: none"> Хялбаршуулсан таньж 01 мэдэх үйл ажиллагаа Нарийвчилсан үйл ажиллагаа Баталгаажуулах үйл ажиллагаа Эцсийн өмчлөгчийг тогтоох үйл ажиллагаа Зуучлагч болон гуравдагч этгээдээр дамжуулан таньж мэдэх үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> Сэжигтэй гүйлгээг илрүүлэх үйл ажиллагаа Санхүү мэдээллийг албанд мэдээлэх үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> Бичиг хэрэг бүртгэл Мэдээллийн хадгалалт Ажилчдад тавих хяналт Комплаенсийн ажилчдыг шалгаруулах бодлого Сургалт зохион байгуулах

ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕК БА КОВИД-19




Сэтгүүлийн энэ дугаараар Дэлхийн банк, Олон улсын эдийн засгийн форум, Кембрижийн их сургуулиас хамтран боловсруулсан “The Global Covid-19 FinTech market rapid assessment study” буюу ковид-19 дэлхийн улс орнуудын финтекийн зах зээлд хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгаанаас хүргэе.

Судалгаанд нийт 119 улсын 1,428 финтекийн компани оролцсон бөгөөд тэдгээрийн дийлэнх нь буюу 79 хувь нь арилжааны зориулалт бүхий финтек компаниуд /зээл, төлбөр тооцоо, хадгаламж г.м/, 21

хувь нь зах зээлийн дэд бүтэц, хангамжийн зориулалт бүхий финтек компаниуд /регтек, alternative credit гэх мэт/-аас бүрдэж байна.

Судалгааны үр дүнд дэлхий даяар финтекийн зах зээлийн үйл ажиллагаанд хэд хэдэн асуудалтай тулгарч байсан хэдий ч нийт салбарын хувьд өсөлттэй байгаа нь тогтоогдсон. 2020 оны 2 дугаар улирлын байдлаар судалгаанд хамрагдсан 13 финтекийн төрлийн 12 нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй дүнтэй байсан байна. Финтекийн салбарт хийгдсэн гүйлгээний тоо болон хэмжээ нь харгалзан 13 ба 11 хувиар өссөн дүнтэй байгаа бол цахим зээлийн үйлчилгээний хувьд бууралттай дүнтэй байна. Цахим зээлийн үйлчилгээ нь өмнөх оны мөн үеэс хэмжээний хувьд 8 хувиар, тоо хэмжээний хувьд 6 хувиар тус тус буурсан гэсэн үр дүн гарсан байна. Цахим төлбөр тооцоо, цахим хөрөнгийн бирж, цахим хадгаламж болон хөрөнгө оруулалтын төрлийн финтек компаниудын гүйлгээний жилийн өсөлт 20 хувиас их байна. Харин цахим банк, цахим “identity”, регтек компаниудын хувьд 10 орчим хувьтай байна.

Зураг 1. Гүйлгээний дүнгийн өсөлт, финтекийн төрлөөр, 2019–2020




Тус судалгаанаас мөн цар тахлын нөлөөллөөс болж хөл хорио тогтоосон улсуудын хувьд хөл хорионы дэглэмээс хамаараад финтекийн салбарын өсөлт харилцан адилгүй байна гэсэн онцлог үр дүн гарсан. Судалгаанд хамрагдсан улсуудын хөл хорионы дэглэмийг сул, дундаж, хатуу гэж ангилж үзэхэд хатуу хөл хорионы дэглэмтэй

улсуудын финтекийн салбарын гүйлгээний дүн сул хөл хорионы дэглэм тогтоосон улсуудынхаас 1.5 дахин өссөн дүнтэй байсан байна. Зөвхөн цахим төлбөр тооцооны хувьд л гэхэд гүйлгээний дүн 2 дахин их өсөлттэй байна.

Хөл хорионы сул, дундаж, хатуу дэглэмтэй улсын финтекийн зах зээлийн гүйлгээний хэмжээ болон тооны өсөлт /2019–2020/




Хөл хорионы хатуу болон сул дэглэм бүхий улсын цахим төлбөр тооцооны гүйлгээний хэмжээ ба тооны өсөлт /2019–2020/



Хөгжиж буй улсуудын финтекийн зах зээлийн өсөлт нь хөгжингүй улсуудынхтай харьцуулахад өндөр гүйлгээний хэмжээний болон тооны хувьд өндөр дүнтэй гарсан байна.

Гүйлгээний хэмжээ ба тооны өсөлт, Дэлхийн банкны ангиллаар



Зохицуулалтын хувьд ковид-19 хөл хорионы чанга дэглэмтэй орнуудын зохицуулалтын дэмжлэг авах хэрэгцээ өндөр байдаг гэсэн үр дүн гарсан.

Тус судалгааны тайланд финтекийн зах зээлд ковид-19-ийн нөлөөг харуулахдаа зах зээлийн төрлөөр, бүс нутгаар зэргээр ангилж хариулсан бөгөөд дэлгэрэнгүйг дараах холбоосоор унших боломжтой.



СУДЛААЧИЙН ИНДЭР

МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ОРЧИН 2020

/СУДАЛГААНЫ ТАЙЛАН/

УДИРДАГЧ:

Доктор, профессор Б.Даваасүрэн

МУИС-ийн Бизнесийн Сургуулийн
Маркетинг, Худалдааны тэнхимийн
эрхлэгч

ГИШҮҮД:

Ж:Оюунчимэг

МҮХАҮТ-ын Бодлого стратегийн газрын
дарга

Доктор Д.Сувдаа

МУИС-ийн Бизнесийн Сургуулийн
Санхүүгийн тэнхимийн дэд профессор

Доктор Д.Энх-Отгон

МУИС-ийн Бизнесийн Сургуулийн
Менежментийн тэнхимийн эрхлэгч, дэд
профессор

Докторант Р.Шарбанди

МУИС-ийн Бизнесийн Сургуулийн
Маркетинг, Худалдааны тэнхимийн багш

О.Түмэн-Амар

МҮХАҮТ-ын Эдийн засгийн судалгааны
институтийн мэргэжилтэн

Бизнесийн орчныг эдийн засаг, засаглал хууль эрх зүй, дэд бүтэц технологи, нийгэм соёл, байгууллагын дотоод орчин гэсэн ерөнхий 5 үзүүлэлт, дэд 12 үзүүлэлтээр авч үзэхэд **Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ нь 2.91 буюу дунд** гэж үнэлэгдэв. Энэ нь 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад үнэлгээ 0.46 пунктээр дээшилж, бага боловч сайжирсан байна. Бизнесийн орчны хүчин зүйлсээс сүүлийн 3 жилд хамгийн эерэг өөрчлөлттэй нь Дэд бүтэц, технологийн орчин (0.69 пунктээр дээшилсэн) ба Эдийн засгийн орчин, Засаглал хууль эрх зүйн орчин хамгийн доогуур үнэлэгдсэн хэдий ч 2017 оны үнэлгээтэй харьцуулахад харгалзан 0.27, 0.38 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Бизнесийн ерөнхий орчны үнэлгээний ерөнхий 5 үзүүлэлтийн хувьд Байгууллагын удирдлага, зохион байгуулалт (3.34), Технологи, харилцаа холбоо (3.28), Нийгмийн хандлага (3.26) үзүүлэлтүүд нь хамгийн

өндөр буюу **дундаас дээгүүр** сайн талдаа эерэгээр үнэлэгдсэн бол Санхүүгийн зах зээл (2.51), Хүн ам зүйн орчин (2.51), Засгийн газрын институцийн тогтолцоо, уялдаа холбоо (2.60) үзүүлэлтүүд нь хамгийн бага буюу **муу талдаа** үнэлэгдсэн байна. Ерөнхий үзүүлэлт тус бүрийг авч үзвэл:

1. **Эдийн засгийн орчинг** Хүний нөөц-ажиллах хүч, Татварын орчин, Санхүүгийн зах зээл гэсэн 3 дэд үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлогч 33 нарийвчилсан үзүүлэлтүүдээр тодорхойлж үзэхэд дэд үзүүлэлтүүдээс Хүний нөөц-ажиллах хүч (2.91) нь **дунд** үнэлгээтэй үнэлэгдсэн бол Татварын орчин (2.62), Санхүүгийн зах зээл (2.51) үзүүлэлт нь **муу талдаа** үнэлэгдсэн. Эдийн засгийн орчны үзүүлэлтүүдийг 2017 оны бизнесийн орчны судалгааны дүнтэй харьцуулж харвал үзүүлэлт бүрээр үнэлгээ нь өссөн байна. Санхүүгийн зах зээлийн үзүүлэлт 0.26 пункт, Татварын орчин 0.23 пункт, Хүний нөөц, ажиллах хүч 0.3 пунктээр харгалзан өссөн.

2. **Засаглал, хууль эрх зүйн орчинг** Засгийн газрын институцийн тогтолцоо уялдаа холбоо, Засгийн газрын үйл ажиллагаа, Бизнесийн эрхзүйн орчин гэсэн 3 дэд үзүүлэлт, 34 нарийвчилсан үзүүлэлтүүдээр тодорхойлж үзэхэд дэд үзүүлэлтүүд (харгалзан 2.6, 2.63, 2.75) бүгд **муу талдаа** үнэлэгдсэн. Эдгээр үзүүлэлтүүдийг 2017 оны судалгааны дүнтэй харьцуулахад Засгийн газрын институцийн тогтолцоо, уялдаа холбоо хүчин үзүүлэлт 0.42 пункт, Засгийн газрын үйл ажиллагаа 0.43 пункт, Бизнесийн хууль, эрх зүйн үзүүлэлт 0.27 пунктээр харгалзан өссөн, өөрөөр хэлбэл үзүүлэлт бүрийн үнэлгээ нь өссөн байна.

3. **Дэд бүтэц, технологийн орчинг** Үндсэн дэд бүтэц, Технологи-харилцаа холбоо гэсэн 2 дэд үзүүлэлт, 14 нарийвчилсан үзүүлэлтүүдээр тодорхойлж үзэхэд дэд үзүүлэлтүүд харгалзан 3.28, 3.19 үнэлгээтэйгээр бусад орчны үнэлгээнээс хамгийн өндөр буюу **дунд** үнэлгээтэй, **эерэг** хандлагатай үнэлэгдсэн. Дэд бүтэц, технологийн орчны үзүүлэлтүүдийг **2017 оны** бизнесийн орчны судалгааны дүнтэй харьцуулбал үзүүлэлт бүрээр үнэлгээ нь өссөн эерэг үр

дүн харагдаж байна. Технологи, харилцаа холбооны үзүүлэлт 0.89, Үндсэн дэд бүтцийн үзүүлэлт 0.5 пунктээр харгалзан өсчээ.

4. **Нийгэм, соёлын орчинг** Нийгмийн хандлага болон Хүн ам зүй гэсэн 2 дэд үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлогч 10 нарийвчилсан үзүүлэлтүүдээр тодорхойлж үзэхэд дэд үзүүлэлтүүдээс Хүн ам зүй (2.51) нь харьцангуй **муу талдаа** үнэлэгдсэн бол Нийгмийн хандлага (3.26) үзүүлэлт нь харьцангуй өндөр буюу **дундаас дээгүүр** үнэлэгджээ. Анхаарал татахуйц зүйл нь Нийгмийн хандлагыг тодорхойлох бүх үзүүлэлт дундаас дээгүүр үнэлэгдэж, харин Хүн ам зүйгээс Хүн амын тогтвор суурьшил (2.83) үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд нь **муу талдаа** үнэлгээ авсан байна.

5. **Бизнесийн дотоод орчин** буюу байгууллагын үйл ажиллагааны орчинг Байгууллагын удирдлага, зохион байгуулалт болон Үр ашиг, бүтээмж гэсэн 2 дэд үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлогч 13 нарийвчилсан үзүүлэлтүүдээр тодорхойлж үзэхэд Удирдлага, зохион байгуулалт (3.34) дундаас дээгүүр **сайн талдаа** үнэлэгдсэн бол Байгууллагын үр ашиг, бүтээмж (2.94) нь дундаас бага зэрэг **доогуур** үнэлэгджээ. Эдгээр үзүүлэлтүүдийн үнэлгээг **2017 оны** бизнесийн орчны судалгааны дүнтэй харьцуулан үзвэл Удирдлага, зохион байгуулалтын үзүүлэлт 0.68 пункт, Байгууллагын үр ашиг, бүтээмжийн үзүүлэлт 0.35 пунктээр тус бүр өссөн эерэг үр дүнтэй байна.

Бизнес эрхлэх нөхцөл байдлыг нарийвчлан судалж үзэхэд аж ахуйн нэгжүүд бизнесээ санхүүжүүлэх эх үүсвэр олоход төвөгтэй, эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл, зөвшөөрөл авахад хүндрэлтэй, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь бизнес эрхлэхэд саад учруулж байна гэж үзсэн. Харин татварын орчин, шинэ бизнесээ болон өмч хөрөнгөө бүртгүүлэх үйл явц, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах байдал дундаж түвшинд гэсэн байна.

Хүний нөөцийн олдцыг судалж үзэхэд нягтлан бодогч, санхүүч, хүний нөөцийн мэргэжилтэн, борлуулалтын мэргэжилтэн

хангалттай гэж судалгаанд оролцогчдын 45–57 хувь нь хариулсан нь бусад мэргэжилтэй харьцуулахад хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт **хангагдаж** байна гэж үзэж болохоор байна. Харин судалгаанд оролцогчдын 39% нь ур чадвартай мэргэжлийн ажилчдыг, 36% нь гадаад худалдааны менежер, 34% нь дээд түвшний удирдах ажилтан, 32% нь инженер техникийн ажилтан, 30% нь мэдээллийн технологийн мэргэжилтэнийн олдоч **хангалтгүй, хомсдолтой** гэж үзжээ.

Бизнесийн өрсөлдөөний төлөвийг судалж үзэхэд дийлэнх буюу 64% нь бизнесийн гол өрсөлдөгчөө дотоодын аж ахуйн нэгжүүд гэсэн бол 21% нь Хятадын импортын бараа, 11% нь Монголд үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд гэж үзсэн байна.

Монгол Улсад шинээр бизнес эрхлэхэд **хүндрэлтэй** (2.44) байна. Ялангуяа бизнесээ эхлүүлэхэд хөрөнгө, санхүүжилт дутагдалтай (2.17), шинэ бизнес эхлүүлэх зардлыг гаргахад хүндрэлтэй (2.35), бизнес эрхлэхийн тулд авдаг техникийн нөхцөл, зөвшөөрлийн процесс төвөгтэй, хүнд сурталтай (2.34) гэжээ. Иймд гарааны бизнесийг дэмжсэн төрийн бодлого хэрэгжүүлэх, шинэ бизнесийг санхүүжүүлэх боломжийг нээх, мөн төрийн байгууллагаас олгох эрх, зөвшөөрлийг дагалдан бий болдог олон шат дамжлага, хүнд суртал, авилгал, зардал, цаг хугацааг багасгахын тулд төрийн үйлчилгээг цахимжуулж, цахим шилжилт хийх шаардлага өндөр байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Шинээр бизнес эрхлэхэд тулгардаг хүндрэлийг бизнесийн салбаруудаар үнэлэхэд хамгийн их ажлын байр шингээдэг, хамгийн олон аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг Худалдаа (2.59), Үйлчилгээний (2.55) салбарт шинэ бизнес эхлүүлэхэд **бэрхшээлтэй** байгаа нь худалдаа, үйлчилгээний салбарт шинээр бизнес эрхлэхэд шаарддаг шалгуур, стандарт, зөвшөөрлийг дахин нягталж шаардлага байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчид гадаад худалдаа эрхлэх нөхцөл байдлыг мөн л **хүндрэлтэй** гэж үнэлсэн ба дийлэнх нь экспорт, импортын зөвшөөрөл авахад зарцуулах хугацаа их, зөвшөөрөл авахын тулд бүрдүүлэх бичиг баримтын тоо олон, зөвшөөрөл авахад гарах зардал, төлбөр хураамжийн хэмжээ өндөр гэж хариулсан. Валютын ханшийн хэлбэлзлийн нөлөө **маш их хүндрэл** үүсгэж байгааг онцгойлон анхаарах шаардлагатай байна. Мөн экспорт, импорт хийхэд дотоодын тээврийн зардал

өндөр, тээвэрлэлтэд зарцуулах хугацаа **их**, тээврийн олдоч, хүрэлцээ **хангалтгүй** байгаа нь гадаад худалдаа эрхлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Бизнесийг төрийн ба төрийн бус байгууллагуудын үзүүлдэг дэмжлэгийн талаар бизнес эрхлэгчид арилжааны банкууд, МҮХАҮТ болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын бизнест үзүүлэх дэмжлэг **илүү**, харин эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, Олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, Бизнесийн зөвлөгөө өгөх төвүүдийн бизнес дэх дэмжлэг **тааруу** байна гэж үнэлсэн. Судалгаанд оролцогчид Засгийн газар (44.8%), Орон нутгийн засаг захиргааны байгууллагын (24.3%) дэмжлэг тэдний бизнест хамгийн чухал **хэрэгцээтэй** гэж үзсэнээс 1.5 тэрбумаас доош бага орлоготой бизнес эрхлэгчид Засгийн газар, Орон нутгийн засаг захиргаа, Арилжааны банкны дэмжлэгийг, 1.5 тэрбумаас дээш орлоготой бизнес эрхлэгчдийн хувьд МҮХАҮТ болон үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн холбоодын дэмжлэгийг **чухал** гэсэн байна.

Бизнес эрхлэхэд төрийн байгууллагуудын үзүүлж буй **үйлчилгээг** 6 үндсэн үзүүлэлтээр үнэлж үзэхэд **дундаас доогуур** (2.91) үнэлэгдсэн. Төрийн болон төрийн бус байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс Төрийн үйлчилгээний цахимжуулалт (3.34), Төрийн нэг цэгийн үйлчилгээ (3.19), Үзэсгэлэн худалдаа (3.05) зэрэг нь бизнест **дундаж дэмжлэг** болсон. Харин гадаадын төсөл, хөтөлбөрүүд (1.98) **дэмжлэг болоогүй** гэж үнэлжээ. Төрийн үйлчилгээний цахимжуулалтад өгсөн үнэлгээ 3.34 болж **2017 оныхоос** 0.36 пунктээр, төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээний үнэлгээ 3.19 болж 0.2 пунктээр, үзэсгэлэн худалдаа 3.05 болж 0.08 пунктээр тус тус сайжирсан байна. Харин Хөрөнгө оруулалтын урамшууллын бодлого арга хэмжээний үнэлгээ 2.11 болж 0.31 пунктээр буурчээ.

Монголын **бизнесийн орчинг сайжруулахын** тулд нэн тэргүүнд хэрэгжүүлбэл зохих эхний 5 арга хэмжээнд Бизнесийн зээлийн хүүг бууруулах, зээлийн нөхцөлийг сайжруулах (79.7%), Татварын таатай орчинг бүрдүүлэх (77.9%), Хууль эрх зүйн орчинг сайжруулах (62.9%), Үндэсний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих (58.8%), Авилга, хүнд суртлыг бууруулах (51.5%), түүнчлэн Төрийн оновчтой, тогтвортой бодлогыг тодорхойлох, төрийн үйлчилгээг шуурхай болгох арга хэмжээг судалгаанд оролцогчид онцгойлж үзсэн байна.

Монгол Улс **экспортыг дэмжих бодлогын** хүрээнд эхний ээлжид бизнес эрхлэгчдийг санхүүжилтийн эх үүсвэр олоход (72.9%) нь төрийн зүгээс бодлогоор тууштай дэмжих, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетингийн зөвлөгөө (63.9%) болон гадаад зах зээлд гарахад чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээ (59.8%)–ний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах хэрэгтэй байна.

Судалгааны үр дүнгээс харахад, 2019 онд ААН–үүдийн 33.7%–д нь борлуулалтын орлого өмнөх оноос 10% хүртэл, 23.4%–д нь 10 ба түүнээс дээш хувиар өсөж, 23.5%–д нь тодорхой хэмжээний бууралт бий болсон бол энэхүү өөрчлөлтийн дүр зураг 2020 онд эсрэг байдалтай болж, нийт ААН–үүдийн 28.1%–д нь борлуулалт 10% хүртэл, 28%–д нь 10 ба түүнээс дээш хувиар буурч, ААН–үүдийн дөнгөж 20 орчим хувьд борлуулалт тодорхой хэмжээгээр өссөн байна. 2020 оны энэхүү бууралт нь Ковид–19 цар тахал, түүнээс сэргийлэх эдийн засгийн арга хэмжээнүүдийн үр дүнд Монгол Улсад эдийн засгийн өсөлт саарч байгаатай шууд хамааралтай.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ажилтны тооны өсөлтийг авч үзвэл, сүүлийн 3 жилийн дунджаар бичил бизнесүүдийн 2.6%, том ААН–үүдийн 1.6% нь ажилтны тоог өссөн. Харин бууралтын хувьд 2020 оны байдлаар 2018 оноос ажилтны тоо буурсан бичил бизнес эрхлэгчдийн тоо 18.5 пунктээр, жижиг бизнесийнхний тоо 18.9 пунктээр, дунд бизнесийнхний хувьд 9.7 пунктээр тус тус буурчээ. Гэтэл том бизнесүүдийн талаас илүү хувь нь сүүлийн 3 жилд ажилтны тоо нь буурсан гэжээ. 2020 онд жижиг, дунд, том бизнес эрхлэгчдийн 50%–с дээш тооны ААН–үүдийн ажилтны тоо буурсан таагүй үр дүнг цаашид онцгой анхаарах шаардлагатай.

Энэ удаагийн судалгаа нь дэлхий дахинд хурдтай тархаж буй Ковид–19 цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд нь эдийн засагт сөргөөр хүчтэй нөлөөлж, улмаар Монгол Улсын эдийн засгийг 2020 оны 1–р улиралд 10.7 хувиар агшаасан (*ҮСХ–ны мэдээ*) таагүй үед явагдсан. Судалгааны эцэст, Монгол Улсын Засгийн газраас 2020 онд Ковид–19 цар тахлаас эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдэд дэмжлэг болсон эсэхийг асуухад **дэмжлэг үзүүлсэн** (48.3–83.5% нь эерэг үр нөлөөтэй, 27.6–33.2% нь маш их нөлөө үзүүлсэн) бөгөөд ялангуяа НДШ–ийн хөнгөлөлт болон ААН–ийн орлогын албан татварын хөнгөлөлт нь чухал нөлөө (77.5–83.5%) үзүүлсэн болохыг онцолсон байна.

ТАНИЛЦУУЛГА

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН



Creating Markets, Creating Opportunities

Дэлхийн банкны бүлгийн гишүүн байгууллага болох ОУСК нь хөгжиж буй орнууд дахь хувийн хэвшлийг дэмжих зорилготой дэлхийн хамгийн том хөгжлийн байгууллага юм. Дэлхий даяар нийтдээ 100 гаруй улс орнуудын хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран, өөрсдийн мэдлэг, нөөц бололцоогоо ядуурлыг бууруулах, баялгийн тэгш хуваарилалтыг дэмжихийг гол зорилгоо болгодог.

2020 оны санхүүгийн жилд хувийн хэвшилд оруулсан нийт хөрөнгө оруулалт 22 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд бид хувийн хэвшлийн хүчин чадал, бололцоонд тулгуурлан ажлын байр бий болгох, хөгжлийн тулгамдсан бэрхшээлүүдийг даван туулахад анхаарч ажиллаа.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн болон байгаль орчны хамгаалалттай холбоотой зорилт, бэрхшээлүүдийг шийдвэрлэх зорилгоор ОУСК нь төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. 1997 онд анх хөрөнгө оруулалт хийснээс хойш ОУСК-аас Монгол Улсад нийтдээ 2.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг 30 гаруй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан олгосон байна. КОВИД-19 цар тахалтай холбоотой эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ОУСК-аас Монгол улсын санхүүгийн салбарын тогтвортой байдал, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн үйлчилгээ авах боломжийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

ОУСК-аас Санхүүгийн зохицуулах хороотой дараах гол хоёр чиглэлийн хүрээнд хамтран ажиллаж байна. Үүнд: Ногоон санхүүжилтийг хөгжүүлэх; мөн ii) Жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжийг Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх замаар сайжруулах.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд ОУСК нь СЗХ-той хамтран Монгол Улсад ногоон санхүүжилтийн зах зээл, ялангуяа ногоон бонд гаргахад чиглэсэн заавар, зөвлөмжийг боловсруулж, байгаль орчинд ээлтэй төсөл, бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарах юм. Мөн байгаль орчин, нийгмийн болон засаглалын шаардлагуудыг санхүүгийн байгууллагуудын зээл, санхүүжилт олгох үйл ажиллагаанд нэвтрүүлэх, санхүүгийн салбарт уур амьсгалтай холбоотой эрсдэлийг үнэлэх, бодлого боловсруулах үйл ажиллагаанд тусгахад туслах болно.

Монгол Улс хөдлөх хөрөнгө барьцаалан зээл, санхүүжилт авах боломжийг бий болгоход шаардлагатай суурь тогтолцоог амжилттай хөгжүүлсэн боловч энэхүү зах зээлийн хэмжээ бага хэвээр байна. Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд зээл авах харьцангуй шинэ арга зам бөгөөд тэдгээртэй хамтран ажилладаг томоохон худалдан авагч эсвэл ханган нийлүүлэгчдийн зээл авах боломж, зээлийн зэрэглэлийг ашиглан санхүүжилт авах тухай ойлголт юм.

ОУСК нь дэлхийн хөгжиж буй орнууд дахь уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжигч хамгийн том санхүүжүүлэгч байгууллагуудын нэг билээ. Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлтийг дэмжих чиглэлээр хувийн хэвшлийн төслүүдэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор ОУСК нь Ногоон бондын хөтөлбөрийг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. 2020 оны 6-р сарын 30-ны байдлаар, ОУСК-аас 20 төрлийн валютаар 10 гаруй тэрбум ам.долларын 172 удаагийн ногоон бондыг зах зээл дээр амжилттай гаргажээ.

ОУСК нь өнгөрсөн хугацаанд Колумб, Хятад, Гана, Вьетнам зэрэг дэлхийн 40 гаруй хөгжиж буй орнуудад хөдлөх хөрөнгө барьцаалан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд тусалсан байна. Монгол улсад нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааг Швейцарын засгийн газрын Эдийн засгийн хэрэг эрхлэх газрын (SECO) дэмжлэгтэй хэрэгжүүлнэ.



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил,

захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг” хэлнэ гэж томъёолсон байдаг.

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН СУУРЬ ГЭМТ ХЭРГҮҮД



Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд тэр нь мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- Хууль бус галт зэвсгийн наймаа
- Хүний, эд эрхтний наймаа
- Хар тамхины худалдаа
- Бусдын биеийг үнэлүүлэх
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар боловсруулах
- Авлига, хээл хахууль
- Татвараас зайлсхийх
- Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг
- Хулгай, дээрэм
- Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр,

далд веб дэх хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн, этериум зэрэг криптовалютуудад олсон орлого гэх мэт

Иймд гэмт хэрэгтнүүд хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоо мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл, хууль хяналтын байгууллагын анхаарлыг татахгүй, тэдний хараанд өртөлгүйгээр зарцуулах боломжтой болохын тулд санхүүгийн системд нэвтрүүлж, жинхэнэ эх үүсвэрийг нь нуун дарагдуулж, төөрөгдүүлэх замаар хууль ёсны орлого мэт харагдуулахыг зорьдог.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх нь” гарын авлагыг гаргасан. Энэхүү гарын авлагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ, хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг холбоотой мэдээ, мэдээллийг олж авна. Иймд та бүхэн гарын авлигатай уншиж танилцах бол <http://www.frc.mn/p/c/25> цахим хуудсаар зочлоорой.


ХЭРЭГЛЭГЧ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 3 дугаар улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 130 өргөдөл, гомдол ирсэн байна.



Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбар болон ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоо өссөн байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 130 өргөдөл, гомдол ирснээс дараах байдлаар өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна:

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	108
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	22
Хугацааг нь сунган хянагдаж буй	-

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Өргөдөл, гомдол шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор):



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

“Байгууллагын соёл гэж юу вэ? Товчоор бол албажсан, эсхүл албан бус ёс зүйн зан төлөв, үйл хөдлөлийн хэм хэмжээ юм. Үүнд мөн байгууллага доторхи хамтын харилцааны загварчилсан жишгүүд багтана. Уг соёлыг байгууллагын бүх ажилтан буюу дээд шатны удирдлагаас эхлээд гэрээт ажилтан гээд бүгд хэрэгжүүлнэ.”



Төлөөлөн удирдах зөвлөл/ТУЗ/ нь компанийн үнэт зүйлс болон хэтийн зорилго, стратегийг тогтоох, мөн байгууллагын соёлыг бий болгох, бизнес явуулах арга хэлбэрийг тодорхойлох үүрэгтэй. Ингэснээр компанийн урт хугацааны амжилт болон ирээдүйн өрсөлдөх чадварт нөлөөлж болох технологийн өөрчлөлт, хүрээлэн буй орчны нөлөөлөл болон байгууллагын үндсэн эрсдэл, тодорхойгүй байдал зэргийг ухаалгаар удирдах, шийдвэрлэх боломжийг олгодог.

Өөрөөр хэлбэл, компани зорилгоо нарийвчлан сайн тодорхойлсон цагт бизнесийн загвар, стратеги, эрсдэлд хандах хандлагаа боловсруулахад хялбар болохоос гадна байгууллагын хүний нөөц, үйлчлүүлэгчид болон олон нийттэй харилцахад ч дөхөм болно.

Урт хугацааны тогтвортой байдалд чиглэсэн бизнесийн загвар болон стратегийг удирдах нь цаг хугацаа өнгөрөх тусам үнэ цэнийг бий болгож байдгийг ойлгох нь ТУЗ-ийн хувьд чухал. Энэ нь санхүүгийн тайланд тусгагдсан үзүүлэлтүүдээр хязгаарлагдахгүй. Чадварлаг ажилтан, оюуны өмч, брэндийн танигдалт зэрэг биет бус, үнэ цэнэ бүхий хөрөнгийг хэрхэн бий болгох, удирдах, тогтвортой хадгалах талаар ойлголттой байх хэрэгтэй гэсэн үг.

ТУЗ нь компанийн зорилгыг урт хугацаанд авч үзэх хэрэгтэй байдаг ч хөрөнгө оруулагчид бүгдээрээ урт хугацааны стратегийг ашигладаггүй. Тиймээс урт хугацааны болон богино хугацааны ашиг сонирхлын зөрчлийг үр дүнтэйгээр удирдах, зохицуулах нь ТУЗ-ийн үүрэг юм.

ТУЗ-ийн гишүүд хууль, тогтоомжийн хүрээнд эрх мэдэл, ажил үүргээ гүйцэтгэж, шударга ёсыг дээдлэн баримтлан тухайн байгууллагад зохих үнэт зүйл, зан төлөв, соёлыг төлөвшүүлэхэд нь ТУЗ-ийн даргад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.

ТУЗ нь корпорацийн соёлыг илүү хөгжүүлж, өөрчлөх боломжтой үнэт зүйлсийн хүрээг тогтоодог ба энэхүү байгууллагын соёлд байнгын тасралтгүй анхаарал хандуулж байх шаардлагатай. Хурдацтай өөрчлөгдөж байгаа өнөөгийн орчин, нийгэмд тухайн соёл нь компанийн амжилтад нөлөөлж буй эсэх, зорилго үнэт зүйлтэй уялдаж байгааг тогтмол хугацаанд хянаж үнэлэх хэрэгтэй. Компанид эрүүл соёл төлөвшсөн эсэхийг дараах үзүүлэлтүүдээр таньж болно. Үүнд:

- Шударга байдал;
- Нээлттэй байдал;
- Хүндлэл;
- Дасан зохицох чадвар;
- Итгэлцэл;
- Нэр хүнд;
- Сорилт хүлээн авах чадвар;
- Хариуцлагатай байдал;
- Нэг зорилго дор нэгдэх чадвар гэх мэт.

Харин эсрэгээрээ байгууллагын эрүүл бус соёл байдлаар илэрхийлэгддэг. Үүнд:

- тусгаарлагдсан буюу амиа бодсон сэтгэлгээ;
- гүйцэтгэх захирлын бусдаас хэт давамгайл байдал;
- удирдлагын ихэрхүү, дээрэнгүй зан;
- хэтэрхий их үр дүн, хэрэгжүүлэх боломжгүй зорилтод хүрэхийг шаардах;
- мэдээлэл авах боломж хомс;
- сорилт хүлээн авахад бэлэн биш;
- ёс зүйн дүрэм, харилцааны хэм хэмжээний зөрчлийг хүлцэн тэвчих;
- тухайн асуудалд богино хугацаанд анхаарал хандуулах;
- хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцээгүй шагнал, урамшуулал олгох гэх мэт.

Компанийн үнэт зүйлийг тодорхойлохдоо удирдлагын зүгээс нийт ажиллагсдын санаа бодлыг тусгаж, хамтран тодорхойлвол илүү үр дүнтэй байдаг аж. Компанийн удирдлага өөрийн шийдвэр, эсвэл үйлдлээрээ байгууллагын үнэт зүйлстэй зөрчилдөж буй мессеж өгөхөөс зайлсхийж байх нь итгэлцлийн хувьд чухал юм.

Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн зан байдал, шийдвэр, үйл хөдлөлөөрөө тухайн үнэт зүйлсийг бэхжүүлж байдаг ба ТУЗ нь компанийн зорилго, үнэт зүйлсийг бодлого болон байгууллагын бүх түвшний үйл ажиллагаандаа тусгах хэрэгтэй. Ялангуяа шагнал, урамшуулал, албан тушаал ахих зэрэг шийдвэрийг байгууллагын үнэт зүйлстэй нийцүүлэх шаардлагатай.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АЛБАНИ УЛСЫН КОВИД-19-ИЙН НӨЛӨӨЛЛИЙН ЭСРЭГ ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХЭД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО

ЗАСГИЙН ГАЗРААС АВСАН АРГА ХЭМЖЭЭ

1. Албани улсын Засгийн газраас Аж ахуйн нэгжид, тэр дундаа дунд болон томоохон компаниудад үзүүлж буй дэмжлэг

Дунд болон томоохон компаниудын цалингийн нөхөн олговор

- Ажилчдын цалин хөлсийг санхүүжүүлэх зорилгоор дунд болон томоохон компаниудын зээлийг баталгаажуулахын тулд 100 сая долларыг бүрэн эрхийн баталгаа хэлбэрээр санал болгосон.
- Бизнес эрхлэгчид үндсэн ажилчдын нийт цалингийн 3 сарын үнийн дүн хүртэл зээл авах өргөдөл гаргах боломжтой (мөн нийгмийн даатгал, тэтгэвэр орно) ба энэ зээлээр компани 150,000 Албани мөнгөөр ажилчдын цалинг төлөх боломжтой болсон.

Зээл олгох нөхцөл

- Зээл нь хөнгөлөлттэй хүүтэй бөгөөд 2.85 хувиас хэтрэхгүй ба зээлийн эрсдэл нь автоматаар төрд шилждэг.
- Зээлийг баталснаас хойш эхний 3 сард зээлдэгч зээлийн үндсэн төлбөрийг төлөх шаардлагагүй бөгөөд эдгээр төлбөрийг Сангийн яам хариуцна.
- Зээлийг хоёрдугаар түвшний банкнаас баталснаас хойш бизнес эрхлэгчид 2 жилийн дотор хэсэгчлэн төлж болно.

Шаардлага

- Өргөдлийг бизнес эрхлэгчид шууд хоёр дахь шатны банкуудад өгөх ёстой.
- Хэрэв зээлдэгч нь тохиролцсон нөхцлийн дагуу зээлдүүлэгчид буцааж төлөхгүй бол зээлдэгч нь зээлийн эргэн төлөлтийг хангахын тулд компанийг хяналтандаа авах, тухайн компанийн хувьцааг худалдах эрхтэй.

2. Албани улсын Засгийн газраас Аж ахуйн нэгжид, тэр дундаа жижиг компаниудад ба хувь хүмүүст үзүүлж буй дэмжлэг

Жижиг компаниуд, хувь хүмүүст үзүүлэх дэмжлэг

Дээр дурдсан томоохон болон дунд компанийн схемээс гадна 65 сая ам.долларыг нэн яаралтай хэрэгцээтэй байгаа хүмүүс (жишээ нь, дэгдэлтийн улмаас ажилгүйдэлд нэрвэгдсэн хүмүүст), жижиг компаниудад олгох боломжтой.

Ашиг хүртэх ангиллууд нь:

- Хувиараа бизнес эрхэлдэг хувь хүмүүс;
- Арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэний гэр

бүлийн цалингүй ажилчид;

- Арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүмүүс;
- Хуулийн этгээдийн ажилтнууд.

Шаардлага

Энэхүү буцалтгүй тусламжийн санхүүжилтэд хамрагдахын тулд жижиг компаниуд эсвэл хувь хүмүүс хөнгөлөлтөд хамрагдах эсэхээ тодруулахаар онлайн хүсэлтээ Татварын Ерөнхий газарт ирүүлэх ёстой. Энэ үе шатанд мэргэшлийн шалгуурыг олон нийтэд нээлттэй болгоогүй бөгөөд өргөдөл тус бүрийг тохиолдлоор нь үнэлдэг.

Энэхүү хөтөлбөрт хамрагдахаар бүртгүүлсэн ажилтан, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд сар бүр 26,000 Албани мөнгөөр төлбөр төлөх болно. Энэ нь Албани улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хамардаг бөгөөд хэрэв хүлээн зөвшөөрвөл тухайн хүний ердийн цалингаас үл хамааран авах болно.

3. Ажил эрхлэлтийг дэмжих – нэмэлт арга хэмжээ

Дараах ангиллын цалингийн нөхөн олговор:

Нэг хүнд сард 320 еврогийн санхүүгийн туслалцааг дараах хүмүүс авах боломжтой.

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын тушаалын дагуу үйл ажиллагаагаа хаасан дунд / том аж ахуйн нэгжийн ажилтнууд.
- 2020 оны 3-р сарын 24-өөс 2020 оны 4-р сарын 10-ны өдрийн хооронд Ковид-19-ийн нөхцөл байдлаас болж ажилгүй болсон ажилтнууд;
- 2020 оны 3-р сарын 24-ний өдөр Ковид-19-ийн нөхцөл байдлаас шалтгаалан жижиг аж ахуйн нэгжүүд, ажил олгогч нь захиалгын дагуу үйл ажиллагаа эрхлэх боломжтой байсан ч ажилгүй болсон ажилтнууд.
- Дараах салбарт ажилладаг ажилчдад цалингийн нөхөн олговор өгнө:
 - хүнс, жимс, хүнсний ногоо, эмийн бүтээгдэхүүний худалдааны салбар;
 - хуульч, нотариатч, эмч мэргэжилтэн, эм зүйч, сувилагч, малын эмч, архитектор, инженер, эмч-лабораторийн техникч, дизайнер, эдийн засагч, агрономич, бүртгэлийн нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин зэрэг бүртгэгдсэн мэргэжлүүд.

4. Нийгмийн хамгаалал

Ковид-19-ийн хямралаас үүдэн нийгмийн хамгааллыг хангах нөөц сан болох 58 сая ам.долларыг дараах хүмүүст тус тус зарцуулж байна. Үүнд:

- Ажилгүйдлийн тэтгэмж, нийгмийн тусламжийн хуваарийг хоёр дахин нэмэгдүүлж буй эмзэг бүлэгт;
- Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаагаа зогсоохоос өөр аргагүй болсон жижиг бизнес эрхлэгчид / хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд.

5. Тэтгэвэр

Дөрөвдүгээр сарын тэтгэврээс тэтгэвэр авагч бүрт ногдох тэтгэврийн хэмжээг 2.3%-иар индексжүүлсэн.

Албани улсын засгийн газрын энэхүү шийдвэрээс тэтгэвэр авагчдад зориулж 17.2 сая евро хуваарилжээ.

6. 2 дахь удаагийн Засгийн газраас гаргаж буй тусламжийн багц

- 4-р сарын 15-ны өдөр батлагдсан хоёр дахь багцад 7 тэрбум Албани мөнгийг (ДНБ-ий 0.4 хувь) сангаас эхний багцад ороогүй цар тахлын нөлөөнд өртсөн жижиг аж ахуйн нэгжийн ажилчдад нэг удаагийн шилжүүлэг болох 40,000 Албани мөнгийг төлөх саналыг багтаасан.
- Мөн цар тахлын өмнө татварын шаардлага хангасан хувийн хэвшлийн бүх компаниудад эргэлтийн хөрөнгөд зээл олгох 15 тэрбум Албани мөнгөний (ДНБ-ний 0.9 хувь) бүрэн хэмжээний баталгаа гаргасан. Засгийн газар зээлийн 60 хувьд баталгаа гаргах бөгөөд хүүгийн хэмжээг таван хувь байхаар тогтсон.

7. 3 дахь удаагийн Засгийн газраас гаргаж буй тусламжийн багц

- Гурав дахь жижиг дэмжлэгийн багцыг наймдугаар сарын 13-ны өдөр баталж, хөл хорио эхлээд нэг сарын дараа ажилдаа орсон нийтийн тээврийн ажилчдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмж олгожээ.
- Засгийн газар татварын хойшлуулах арга хэмжээг бүх томоохон компаниудад (банк, харилцаа холбоо, нийтийн аж ахуйн нэгж, бусад зайлшгүй шаардлагатай бизнесээс гадна) ашгийн албан татварын 2020 оны хоёр, гуравдугаар улирлын төлбөрийг 2021 он хүртэл хойшлуулах боломжийг олгосон.
- 9-р сард засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хөтөлбөр нь

хорио цээрийн үеэр ажилгүй болсон хүмүүсийн ажлын байрны зардлын тодорхой хэсгийг нөхөх зорилготой юм. Албан ёсны салбарын ажилчдын хувьд засгийн газар хөдөлмөрийн хөлсний хагасыг (хуулиар тогтоосон доод түвшинд), ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хөтөлбөрийн туршид (4 эсвэл 8 сар) бүрэн хариуцах болно.

- Парламентаас 11-р сарын 16-ны өдөр баталсан 2021 оны төсвийн Ковид-19-тэй холбоотой зардалд 14.2 тэрбум (ДНБ-ний 0.8 хувь) –ыг хуваарилла. Үүнд Ковид-19 эмчилгээний 7.2 тэрбум Албани мөнгө, эмч, сувилагчдын цалингийн нэмэгдэлд 4.5 тэрбум Албани мөнгө, нийгмийн тусламж, ажилгүйдлийн тэтгэмжийн төлбөрийг түр хугацаанд нэмэгдүүлэхэд 2.5 тэрбум Албани мөнгө орно.

ТӨВ БАНКНААС АВСАН АРГА ХЭМЖЭЭ


1. Компаниуд болон иргэдийн хөрвөх чадварын гацааг арилгахын тулд Албани улсын төв банкнаас зээлийн ангилал, нөхцөлийг бүрдүүлэхэд тавигдах шаардлагыг түр хугацаагаар түдгэлзүүлэх хугацааг 8-р сарын 31-ний өдрийг хүртэл сунгаж, үйлчлүүлэгчдэд зээлийн төлбөрийг торгуульгүйгээр хойшлуулахыг банкнаас хүсэх боломжийг олгов. 5-р сарын 28-ны өдөр Албани улсын төв банк нь зээлдэгчдийн зээлийн ангиллыг бууруулахгүй байхаар тооцоолж 2020 онд багтаан банкуудын зээлийн бүтцийн өөрчлөлт хийх журмыг батлав. Зээлийн хатуу ангилалд оруулах хугацааг 2022 он хүртэл нэг жилээр хойшлуулав.
2. 3-р сарын 25-ны өдөр Албани улсын төв банк бодлогын үндсэн хүү болох долоо хоног тутмын репо-гоо 50 нэгжээр бууруулж, түүхэн доод хэмжээ 0.5 хувьд хүргэлээ.
3. Албани улсын төв банк хөрөнгө нэмэгдүүлэх, зээл олгохыг дэмжих зорилгоор 2020 оныг дуустал банкуудад ногдол ашиг хуваарилах үйл ажиллагааг зогсоов. Төв банк мөн тахлын үеэр хяналтын зөвлөл, дээд удирдлагынхаа цалинг хоёр дахин бууруулсан байна.
4. Интернет банк ашиглахыг уриалж, банкны байранд үйлчилгээ эрхлэх шаардлагатай хүмүүсийн тоог багасгахын тулд Төв банк мөн үндэсний мөнгөн тэмдэгтээр шилжүүлэг хийх шимтгэлээс татгалзав.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ

2020
□ 10


Хөрөнгийн зах зээл

33Ү /их наяд төгрөг/




Дунджаар 2.59 их наяд төгрөгт хүрсэн.

ТОП-20 индекс




17,458.1 буюу өмнөх сарын дунджаас 287.9 индексээр өссөн.

MSE A индекс



8,126.6 буюу өмнөх сарын дунджаас 122.1 индексээр буурсан.

MSE Б индекс



7,431.7 буюу өмнөх сарын дунджаас 25.7 индексээр нэмэгдсэн.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, www.mse.mn

Бүртгэлтэй үнэт цаасны тоо ширхэг

15,138,005,043

Хоёрдогч хувьцааны арилжааны үнийн дүн

/тэрбум төгрөг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Биелсэн хэлцэл

96

Богцын нийт хэмжээ

15,922

Богцын нийт үнийн дүн

5.1

/тэрбум төгрөг/

Нэгж богцын дундаж үнэ

517,9

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж, www.mse.mn

Americas

S&P 500 /^GSPC/

3,269.96

Vol 845,497,980

Dow Jones indus.AVG

26,501.6

Vol 142,836,358

Nasdaq composite index

10,911.59

Vol 874,510,482

NYSE composite index

12,429.28

Vol 1,193,366,900

Asia Pacific

Topix index /tokyo/

1,579.33

Vol 1,310,329,900

Nikkei 225 /^N225/

22,977.13

Vol 766,608,300

Hang seng index

24,107.42

Vol 2,537,744,198

S&P/ASX 200 index

5,927.58

Vol 871,366,470

Europe, Middle East & Africa

Euro stoxxs 50 Pr

2,958.21

Vol 467,907,483

FTSE 100 index

5,577.27

Vol 809,675,703

DAX index

11,556.48

Vol 85,600,358


CAC 40 index

4,594.24

Vol 109,096,908

ОЛОН
УЛСЫНХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛ2020 оны 10 дугаар сарын 30-ны
өдрийн байдлаарЭх сурвалж: www.bloomberg.com

2020
□ 10



Эх сурвалж: Албан журмын даатгагчдын холбоо



Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС


Таваарын ханш

2020 оны 12 дүгээр сарын 23-ны өдөр

Crude oil /WTI-New York/ Copper /LME/
Gold Spot /ounce/ Coal /Tianjin

S&P 500 /^GSPC/


3,687.26 -7.66 (-0.21%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


26,751.24 +88.40 (+0.33%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


6,444.95 -6.88 (-0.10%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nasdaq 100 Dec 20 (NQ=F)

12,723.75 +13.75 (+0.11%)



Эх сурвалж: www.Bloomberg.com

📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

☎ +976-51-264444

@ press@frc.mn

🌐 www.frc.mn

📺 Санхүүгийн зохицуулах хороо

🐦 @FRC_of_Mongolia